## УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Увс-АЗЗА” ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: УВА-2023/02/НА-СТА-ТӨА**

Цахим хуудас: www.audit.mn

Улаангом хот

2023 он


Увс аймаг дахь Төрийн аудитын газар,

Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

Ахлах аудитор: Т.Намжил

Утас: 70453721, Цахим хаяг: NamjilT@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт ........................................
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан ........................................
3. Санхүүгийн тайлангийн тодруулга........................................
3.1 Компани, түүний үйл ажиллагаа ........................................
3.2 Компанийн гадаад, дотоод орчин ........................................
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........................................
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад гарсан өөрчлөлт.......
4. Аудитын тайлан ........................................
4.1 Ерөнхий зүйл ........................................
4.2 Материаллаг байдал ........................................
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .........
4.4 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт ........................................
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........................................
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал........................................
5. Аудитын илрүүлэлт ........................................
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл........................................

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| СТОУС | Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2023.03.15 № УВА-2023/02/НА-СТА-ТӨА.
танай ____________-ны №______________-т

"УВС –АВТО ЗАМ ЗАСВАР, АРЧЛАЛТ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Р.ТӨМӨРЧӨДӨР ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Увс-Авто зам засвар, арчлалт" Төрийн өмчит хувьцаат компанийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол "Увс-Авто зам засвар, арчлалт" Төрийн өмчит хувьцаат компанийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

"Увс-Авто зам засвар, арчлалт" Төрийн өмчит хувьцаат компани нь 6 сард олгосон цалингийн урьдчилгаа 2,000.0 мянган төгрөгийг суутган тооцоогүй, санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй, Баруун бүсийн авто зам, завсар арчлалт хариуцсан компаниудын ажилтан албан хаагч болон замчдын хооронд явагдах спортын тэмцээний зардалд 6,000.0 мянга, тэмцээний хувцасны зардалд 1,200.0 мянга, бэлтгэл сургуулилтын зардалд 960,0 мянга, Баян-Өлгий аймагт болсон тэмцээнд оролцох албан томилолтын зардалд 784.0 мянга, нийт 8,944.0 мянган төгрөгийг компанийн ТУЗ-ийн шийдвэргүйгээр зарцуулсан, 2022 оны 5 дугаар сард "УВС-АЗЗА" ТӨХК-аас "Мөнхжим Өргөө" ХХК-д 46,606.1 мянган төгрөгийн барилгын материал ямар нэгэн шийдвэргүйгээр, гэрээ байгуулахгүйгээр хүлээлгэн өгч жилийн эцсийн санхүүгийн тайланд тооцоо нийлж авлагаар тусгасан, мөн жирэмсэн амаржсаны амралттай байсан 1 ажилтанд цалин гаргаж 830.0 мянган төгрөг олгож санхүүгийн тайланд авлагаар тусгасан зэрэг нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтад "Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах",

0200000252

6.4.8 дахь заалтад “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4 дэх заалтад “Үнэн, зөв байх”, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2 дахь заалтад “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, 20.2.5 дахь заалтад “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат, хэмнэлтийн горимыг мөрдүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбогдсон харилцаанд энэ хуулийг мөрдөх ба бусад хуульд өөрөөр заасан бол энэ хуульд заасныг дагаж мөрдөнө”, 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт ”Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална”, 4.1.3 дахь заалтад “үр ашигтай байх”, 4.2.6 дахь заалтад “үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх”, 12.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно”, 12.1.4 дэх заалтад ”хуулиар зөвшөөрөөгүй бусад”, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт “Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно”, Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.4-д “Энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх” гэсэн хуулийн заалтуудад нийцэхгүй, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд “Увс-Авто зам засвар, арчлалт” Төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч нар өөрчлөгдсөн байна.

**Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд 163,577.8 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан нь Улсын чанартай авто замд үүссэн гэнэтийн эвдрэл, бараа материалын үнийн өсөлт, шатах тослох материал, сэлбэгийн үнийн нэмэгдэл, Наранбулаг суманд хийсэн зогсоолын ажлын гүйцэтгэлээр 123,000.0 мянган төгрөгийн, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар–Улаангом сумын Ерөнхий боловсролын 4-р сургууль орчмын замын ажлын гүйцэтгэлээр 41,000.0 мянган төгрөгийн алдагдал хүлээсэн зэргээс шалтгаалжээ.

**Бусад мэдээлэл**

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.БАТСУУРЬ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2021 оны 12-р сарын 31 | 2022 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **ХӨРӨНГӨ** | | |
| **1.1** | **Эргэлтийн хөрөнгө** | | |
| 1.1.1 | Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө | 480,823,554.22 | 500.178.950.16 |
| 1.1.2 | Дансны авлага | 42,401,283.5 | 100,653,210.13 |
| 1.1.3 | Татвар, НДШ – ийн авлага | 8,772,839.07 | 0 |
| 1.1.4 | Бусад авлага | | 830,000 |
| 1.1.5 | Бусад санхүүгийн хөрөнгө | | |
| 1.1.6 | Бараа материал | 181,849,313.55 | 125,316,106.16 |
| 1.1.7 | Урьдчилж төлсөн зардал/тооцоо | | |
| 1.1.8 | Бусад эргэлтийн хөрөнгө | | |
| 1.1.9 | Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) | | |
| 1.1.10 | | | |
| 1.1.11 | **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **713,846,990.34** | **726,978,266.45** |
| **1.2** | **Эргэлтийн бус хөрөнгө** | | |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 746,814,818.94 | 616,859,089.31 |
| 1.2.2 | Биет бус хөрөнгө | 96,516,000.00 | 96,120,000.00 |
| 1.2.3 | Биологийн хөрөнгө | | |
| 1.2.4 | Урт хугацаат хөрөнгө оруулалт | | |
| 1.2.5 | Хайгуул ба үнэлгээний хөрөнгө | | |
| 1.2.6 | Хойшлогдсон татварын хөрөнгө | | |
| 1.2.7 | Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | | |
| 1.2.8 | Бусад эргэлтийн бус хөрөнгө | | |
| 1.2.9 | | | |
| **1.2.10** | **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **843,330,818.94** | **712,979,089.31** |
| **1.3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,557,177,809.28** | **1,439,957,355.76** |
| **2** | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | | |
| **2.1** | **Өр төлбөр** | | |
| 2.1.1 | **Богино хугацаат өр төлбөр** | | |
| 2.1.1.1 | Дансны өглөг | 6,035,391.25 | 526,999.94 |
| 2.1.1.2 | Цалингийн өглөг | | 0.00 |
| 2.1.1.3 | Татварын өр | 3,648,415.70 | 55,252,693.14 |
| 2.1.1.4 | НДШ – ийн өглөг | | 261,502.03 |
| 2.1.1.5 | Богино хугацаат зээл | | |
| 2.1.1.6 | Хүүгийн өглөг | | |
| 2.1.1.7 | Ногдол ашгийн өглөг | | |
| 2.1.1.8 | Урьдчилж орсон орлого | | |
| 2.1.1.9 | Нөөц/өр төлбөр/ | | |
| 2.1.1.10 | Бусад богино хугацаат өр төлбөр | | |
| 2.1.1.11 | Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) -д хамаарах өр төлбөр | | |
| 2.1.1.12 | | | |
| **2.1.1.13** | **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | 9,683,806.95 | **56,041,195.11** |
| **2.1.2** | **Урт хугацаат өр төлбөр** | | |

| | | | |
|---|---|---|---|
| 2.1.2.1 | Урт хугацаат зээл | | |
| 2.1.2.2 | Нөөц /өр төлбөр/ | | |
| 2.1.2.3 | Хойшлогдсон татварын өр | | |
| 2.1.2.4 | Бусад урт хугацаат өр төлбөр | 430,651,551.00 | 430,651,551.00 |
| 2.1.2.5 | | | |
| **2.1.2.6** | **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | 430,651,551.00 | **430,651,551.00** |
| 2.2 | **Өр төлбөрийн нийт дүн** | 440,335,357.95 | **486,692,746.11** |
| **2.3** | **Эздийн өмч** | 177,307,484.23 | 177,307,484.23 |
| 2.3.1 | Өмч:-төрийн | 177,307,484.23 | 177,307,484.23 |
| 2.3.2 | хувийн | | |
| 2.3.3 | хувьцаат | | |
| 2.3.4 | Халаасны хувьцаа | | |
| 2.3.5 | Нэмж төлөгдсөн капитал | | |
| 2.3.6 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 182,793,596.27 | 182,793,596.27 |
| 2.3.7 | Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц | | |
| 2.3.8 | Эздийн өмчийн бусад хэсэг | 166,445,068.62 | 166,445,068.62 |
| 2.3.9 | Хуримтлагдсан ашиг | 590,296,302.21 | 426,718,460.53 |
| 2.3.10 | | | |
| **2.3.11** | **Эздийн өмчийн дүн** | 1,116,842,451.33 | 953,264,609.65 |
| **2.4** | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | **1,557,177,809.28** | **1,439,957,355.76** |

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2021 оны 12-р сарын 31 | 2022 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | **Борлуулалтын орлого (цэвэр)** | 1,740,828,299.08 | **1,976,696,176.92** |
| 2 | Борлуулалтын өртөг | 1,818,603,724.32 | 1,876,253,865.00 |
| **3** | **Нийт ашиг**( **алдагдал**) | (77,775,425.24) | **100,442,311.92** |
| 4 | Түрээсийн орлого | | |
| 5 | Хүүгийн орлого | | |
| 6 | Ногдол ашгийн орлого | | |
| 7 | Эрхийн шимтгэлийн орлого | | |
| 8 | Бусад орлого | 159,478,176.75 | 35,000.00 |
| 9 | Борлуулалт, маркетингийн зардал | 154,152,053.39 | 190,724,659.28 |
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | 55,868,011.03 | 71,560,598.63 |
| 11 | Санхүүгийн зардал | | |
| 12 | Бусад зардал | 1,698,525.99 | 1,769,895,69 |
| 13 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | | |
| 14 | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | | |
| 15 | Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | | |
| 16 | Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз) | | |
| **17** | Бусад ашиг ( алдагдал) | | |
| **18** | **Татвар төлөхийн өмнөх ашиг**( **алдагдал**) | (130,015,838.89) | (163,577,841.68) |
| **19** | Орлогын татварын зардал | | |
| **20** | **Татварын дараах ашиг (алдагдал)** | (130,015,838.89) | (163,577,841.68) |
| **21** | **Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)** | | |
| **22** | **Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)** | (130,015,838.89) | (163,577,841.68) |
| **23** | **Бусад дэлгэрэнгүй орлого** | | |
| | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү | | |

| | | | |
|---|---|---|---|
| | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | |
| | Бусад олз (гарз) | | |
| **24** | **Орлогын нийт дүн** | (130,015,838.89) | (163,577,841.68) |
| **25** | **Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)** | | |

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмч | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **2021 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл** | 177,307,484.23 | 182,793,596.27 | 166,445,068.62 | 776,157,491.10 | 1,302,703,640.22 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | | | | | |
| **Залруулсан үлдэгдэл** | | | | | |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | | | 0 | (130,015,838.89) | (130,015,838.89) |
| Өмчид гарсан өөрчлөлт | | | | | |
| Зарласан ногдол ашиг | | | | (55.845.350.00) | (55.845.350.00) |
| **2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | 177,307,484.23 | 182,793,596.27 | 166,445,068.62 | 590,296,302.21 | 1,116,842,451.33 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | | | | | |
| **Залруулсан үлдэгдэл** | | | | | |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | | | | (163,577,841.68) | (163,577,841.68) |
| Зарласан ногдол ашиг | | | | | |
| **2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | 177,307,484.23 | 182,793,596.27 | 166,445,068.62 | 426,718,460.53 | 953,264,609.65 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | ҮЗҮҮЛЭЛТ | 2021 оны 12-р сарын 31 | 2022 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | 2,054,426,912.87 | **2,192,353,407.00** |
| 1.1 | Мөнгөн орлогын дүн (+) | 2,054,426,912.87 | 2,192,353,407.00 |
| | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 2,046,326,912.87 | 2,192,353,407.00 |
| | Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого | | |
| | Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | | |
| | Буцаан авсан албан татвар | | |
| | Татаас, санхүүжилтийн орлого | | |
| | Бусад мөнгөн орлого | 8,100,000.00 | 800,000.00 |
| 1.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 2,438,031,707.71 | **2,172,998,011.06** |
| | Ажиллагчдад төлсөн | 429,597,478.00 | 497,856,821.40 |
| | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 146,208,655.37 | 163,091,725.79 |
| | Бараа материал худалдан авахад төлсөн | 1,614,073,084.64 | 1,361,617,594.17 |
| | Ашиглалтын зардалд төлсөн | 185,260.00 | 6,700.00 |
| | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | | |
| | Хүүгийн төлбөрт төлсөн | | |
| | Татварын байгууллагад төлсөн | 231,845,242.20 | 108,835,670.50 |
| | Даатгалын төлбөрт төлсөн | | |
| | Бусад мөнгөн зарлага | 16,121,987.50 | 41,589,499.00 |
| 1.3 | Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | (383,604,794.84) | **19,355,395.94** |
| 2 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| 2.1 | Мөнгөн орлогын дүн (+) | | |
| | Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | | |
| | Биет бус хөрөнгө борлуулсны орлого | | |
| | Хөрөнгө оруулалт борлуулсны орлого | | |
| | Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого | | |
| | Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт | | |
| | Хүлээн авсан хүүгийн орлого | | |
| | Хүлээн авсан ногдол ашиг | | |
| | | | |
| 2.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | | |
| | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | | |
| | Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | | |
| | Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн | | |
| | Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | | |
| | Бусдад олгосон зээл болон урьдчилгаа | | |
| | | | |
| 2.3 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | | |
| 3 | Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | (55,845,350.00) | |
| 3.1 | Мөнгөн орлогын дүн (+) | | |
| | Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | | |
| | Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | | |

| | | | |
|---|---|---|---|
| | Төрөл бүрийн хандив | | |
| | | | |
| 3.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 55,845,350.0 | |
| | Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | | |
| | Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн | | |
| | Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн | | |
| | Төлсөн ногдол ашиг | 55,845,350.00 | |
| | | | |
| 3.3 | Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | 55,845,350.00 | |
| 4 | Валютын ханшийн зөрүү | | |
| 5 | **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | (439,450,144.84) | 19,355,395.94 |
| 6 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 920,273,699.06 | **480,823,554.22** |
| 7 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 480,823,554.22 | **500,178,950.16** |

## 2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

| Д/д | Үзүүлэлтүүд | Хэмжих нэгж | 2021 оны Гүйцэтгэл | 2022 он | | Харьцуулалт | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | 2022 Төл/ 2022 Гүйцэтгэл харьцуулсан хувь | Зөрүү /2022 Төл-2022 Гүй/ |
| 1 | Бүтээгдэхүүн үйлдвэрлэл | мян.төг | 1,740,828.30 | 1,454,545.50 | 1,976,696.18 | 135.9 | 522,150.68 |
| | Үүнээс: Улсын чанартай зам засвар арчлалтын ажил | мян.төг | 1,740,829.30 | 1,454,546.50 | 1,767,178.16 | 121.5 | 312,631.66 |
| 2 | Орон нутгийн чанартай зам засвар арчлалтын ажил | мян.төг | 0.00 | 0.00 | 209,518.02 | | 209,518.02 |
| | **Нийт орлого** | мян.төг | **1,900,307.47** | **1,454,546.50** | **1,976,731.18** | 135.9 | 522,184.68 |
| | Бусад орлого | | 159,478.17 | 0.00 | 35.00 | | 35.00 |
| 3 | **Нийт зардал** | мян.төг | **2,030,322.30** | **1,423,292.30** | **2,140,309.02** | 150.4 | 717,016.72 |
| 3.1 | Үүнээс: Удирдлагын зардалд | мян.төг | 211,718.60 | 267,345.90 | 262,285.26 | 98.1 | (5,060.64) |
| 4 | **Татварын өмнөх ашиг** | мян.төг | -130,015.80 | 31,253.20 | -163,577.84 | -523.4 | (194,831.04) |
| 5 | **Цэвэр ашиг /алдагдал/** | мян.төг | **-130,015.80** | **28,127.90** | **-163,577.84** | -581.6 | (191,705.74) |
| 6 | **Төсвийн төлбөр** | мян.төг | 376,697.10 | 296,302.90 | 363,174.05 | 122.6 | 66,871.15 |
| 6.1 | Аж ахуй нэгжийн орлогын албан татвар | мян.төг | 61,226 | 3,125 | 0 | 0.0 | (3,125.30) |
| 6.2 | Нэмэгдсэн өртгийн албан татвар | мян.төг | 100,308 | 116,364 | 141,418.2 | 121.5 | 25,054.60 |
| 6.3 | Түгээмэл тархацтай ашигт малтмал | мян.төг | 0 | 0 | 1,500.0 | | 1,500.00 |
| 6.4 | Ус ашигласны төлбөр | мян.төг | 13 | 17 | 13.4 | 80.0 | (3.36) |
| 6.5 | Газрын төлбөр | мян.төг | 961 | 961 | 961.2 | 100.0 | - |
| 6.6 | Галт зэвсгийн албан татвар | мян.төг | 0 | 0 | 0 | | - |
| 6.7 | Агаарын бохирдлын төлбөр | мян.төг | 114 | 114 | 165.1 | 144.8 | 51.10 |
| 6.8 | Тээврийн хэрэгслийн татвар | мян.төг | 984 | 1,100 | 753.2 | 68.5 | (346.80) |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6.9 | Гадаадын ажиллах хүч ажиллуулсны татвар | мян.төг | 0 | 0 | 0 | | - |
| 6.1 | Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэл | мян.төг | 146,209 | 131,527 | 163,167.3 | 124.1 | 31,640.42 |
| 6.11 | Үл хөдлөх хөрөнгийн татвар | мян.төг | 1,665 | 1,698.4 | 3,363.8 | 198.1 | 1,665.36 |
| 6.12 | ХХОАТ | мян.төг | 39,213 | 36,928.70 | 48,449.2 | 131.2 | 11,520.50 |
| 6.12 | Бусад | мян.төг | 27,092 | 5,560.0 | 4,882.7 | 87.8 | (677.33) |
| 7 | Төрийн өмчийн ногдол ашиг | мян.төг | 55,845.40 | 4,219.20 | 0.00 | 0.0 | (4,219.20) |
| 8 | Ажиллагсдын тоо | хүн | 49 | 49 | 49 | 100.0 | - |
| 9 | Нийт цалингийн сан | мян.төг | 531,127.00 | 505,872.60 | 657,456.74 | 130.0 | 151,584.14 |
| 10 | Нэг ажилтны сарын дундаж цалин | мян.төг | 903.30 | 860.30 | 1,046.30 | 121.6 | 186.00 |
| 11 | Борлуулалтын орлогын 1 төгрөгт ногдох зардал | төг | 1.1 | 0.98 | 0.92 | 94.2 | (0.06) |
| 12 | Хөрөнгө оруулалт | мян.төг | 67,030.00 | 7,980.00 | 7,980.00 | 100.0 | - |
| 13 | Нийт авлага | мян.төг | 51,174.10 | 63,570.00 | 101,483.21 | 159.6 | 37,913.21 |
| 14 | Нийт өглөг | мян.төг | 440,335.30 | 483,211.50 | 486,692.75 | 100.7 | 3,481.25 |
| 14.1 | Үүнээс: богино хугацаат өр төлбөрт | мян.төг | 9,683.80 | 52,560.00 | 56,041.20 | 106.6 | 3,481.20 |
| 14.2 | Урт хугацаат өр төлбөрт | мян.төг | 430,651.50 | 430,651.50 | 430,651.55 | 100.0 | 0.05 |

## 3. Санхүүгийн тайлангийн тодруулга

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Зам тээврийн хөгжлийн яамтай байгуулсан Зам хариуцагчийн болон засвар арчлалтын ажлыг гүйцэтгэх гэрээний дагуу Увс аймгийн нутаг дээрх Улсын чанартай авто зам, замын байгууламжийн засвар арчлалтын ажлыг хариуцаж түүгээр өнгөрөх тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах гэсэн зорилго дэвшүүлж хэрэгжүүлсэн байна.

“Увс-АЗЗА” ТӨХК-ийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Улсын чанартай авто зам, замын байгууламжийн засвар арчлалт

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Төрийн өмчит хувьцаат компани статустай байна. Өмчийн 100 хувийг төр, үүнээс 100 хувийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар эзэмшиж байна.

Тайлант хугацаанд компани үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

“УВС-АЗЗА” ХК нь АДХГЗ-ны даргын 1992 оны 2 дугаар сарын 01 дүгээр захирамжийг үндэслэн байгуулсан байна. Улмаар 2005 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Төрийн өмчийн хорооны шийдвэрээр “УВС-АЗЗА” ТӨХК болж статус нь өөрчлөгдсөн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй”, 9.5 дахь хэсэгт “хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх,

татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах” гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас томилж байгаа нь Компанийн тухай хууль болон Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21.5.3 дахь заалттай нийцэж байна.

“УВС-АЗЗА” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг 175.0 мянган төгрөгөөр тогтоосон нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалтай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно” гэж заасан байна. Энэ хүрээнд “УВС-АЗЗА” ТӨХК-ийн дүрмийг баримтлан жилийн ажлын зорилт түвшнийг ТУЗ болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраар батлуулан ажилладаг байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3-д “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх гэж заасан байна. Шагнал урамшуулал олгосон, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгалын (цүнх, календарь, мэндчилгээ г.м) зардал гаргаагүй байна. Тайлант онд удирдлагын зардлыг 2,226.7 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“УВС-АЗЗА” ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

"УВС-АЗЗА" ТӨХК-ийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад *нийцсэн,* тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт *тохирсон* байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

"УВС-АЗЗА" ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

"Увс АЗЗА" ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 117,220.4 мянган төгрөгөөр буюу 7.5 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/Мянган төгрөг/

| Үзүүлэлт | 2020/12/31 | 2021/12/31 | 2022/12/31 | Өөрчлөлт |
|---|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3 | 4=3-2 |
| Мөнгөн хөрөнгө | 920,273.7 | 480,823.5 | 500,178.9 | 19,355.4 |
| Авлага | 64,351.5 | 51,174.1 | 101,483.2 | 50,309.1 |
| Биет бус хөрөнгө | 96,912.0 | 96,516.0 | 96,120.0 | (396) |
| Бараа материал | 90,370.5 | 181,849.3 | 125,316.1 | (56,533.2) |
| Үндсэн хөрөнгө | 821,278.8 | 746,814.8 | 616,859.1 | (129,955.7) |
| **Нийт хөрөнгийн дүн** | 1,993,186.6 | 1,557,177.8 | 1,439,957.4 | (117,220.4) |
| Өр төлбөр | 690,482.9 | 440,335.3 | 486,692.7 | 46,357.4 |
| Эздийн өмч | 1,302,703.6 | 1,116,842.4 | 953,264.6 | (163,577.8) |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 1,993,186.6 | 1,557,177.8 | 1,439,957.4 | (117,220.4) |

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд өөрчлөлт гарсан байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 500,178.9 мянган төгрөг болж өмнөх оноос 19,355.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Авлага дансны үлдэгдэл 101,483.2 мянган төгрөг болж өмнөх оноос 50,309.1 мянган төгрөгөөр өссөн байна. Авлага дансны үлдэгдэлд 2019, 2020 онуудад үүссэн барьцааны авлага 29,115.6 мянга, Дэглий цагаан Нисэх онгоцны буудлын явгалах замын барьцааны авлага 13,285.7 мянга, 2022 онд хийж гүйцэтгэсэн Улаангом сумын төвийн хатуу хучилттай автозамын засварын ажлын барьцааны 5 хувь болох 2,463.92 мянга, ХХҮГ-Ахлах 4-р сургууль орчмын зигзаг хавтан, явган хүний замын ажлын барьцаа хөрөнгө 3 хувиар буюу 5,381.9 мянга, Мөнхжим-Өргөө ХХК-аас авах бараа материал-46,606.1 мянга, Хархираа-Доктор ХХК-ийн асфальт бетон замын үлдэгдэл төлбөр-3,800.0 мянга, хүүхэд асрах чөлөөтэй байгаа механик инженер Б.Содномцэрэнд олгосон цалин 830.0 мянган төгрөгийн авлага тус тус байна.

Нийт авлагаас барагдах боломжгүй эрсдэлтэй авлага байхгүй байна. 2023 онд эдгээр авлагуудыг барагдуулах боломжтой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 125,316.1 мянган төгрөг болж өмнөх оноос 56,533.2 мянган төгрөг буюу 31 хувиар буурсан нь өмнөх онуудад бодит хэрэгцээнээс их хэмжээгээр нөөцлөн авч бэлтгэсэн бараа материалуудыг зам засвар арчлалтын ажилд зарцуулсан, "Мөнхжим-Өргөө" ХХК-д 46,606.1 мянган төгрөгийн арматурыг өгч авлагаар тусгаснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 616,859.1 мянган төгрөг болж 129,955.7 мянган төгрөгөөр буурсан нь 2022 оны үндсэн хөрөнгийн элэгдлээс шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн дансанд хөрөнгө оруулалтаар 7,281.8 мянган төгрөгөөр суурин болон зөөврийн компьютер, Принтер зэргийг худалдан авсан болон өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу бараа материал данснаас үндсэн хөрөнгөд шилжүүлэн бүртгэсэн 550.0 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Биет бус хөрөнгө 96,516.0 мянгаас 96,120.0 мянган төгрөг болж 396.0 мянган төгрөгөөр буурсан нь тухайн жилийн элэгдлийн зардлаар буурсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 56,041.2 төгрөг болж, өмнөх оноос 46,357.4 мянган төгрөгөөр өссөн нь 2022 онд төлөх НӨАТ-ыг шилжүүлээгүйгээс шалтгаалсан байна.

Урт хугацаат өр төлбөр 2009 онд үүссэн 430,651.5 мянган төгрөгийн өр байна. Энэ нь Кувейтын сангийн зээлээр авсан машин механизм, тоног төхөөрөмжийн үнэ бөгөөд Засгийн газар, Сангийн яам, ТӨБЗГ-аас энэхүү өр төлбөрийг хэрхэн төлж барагдуулах талаар албан ёсны шийдвэр ирээгүйтэй холбоотой олон жил болж байгаатай холбоотой байна.

Өр төлбөрийн дансны үлдэгдэлд нь аймгийн Татварын хэлтэст 55,252.7 мянга, Нийгмийн даатгалын хэлтэст 261.5 мянга, Хувь хүмүүст бараа материалын үнэ 527.0 мянган төгрөг тус тус байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 953,264.6 мянган төгрөг болж 163,577.8 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь хуримтлагдсан ашиг буурсантай холбоотой байна.

Тайлант үеийн хуримтлагдсан ашиг 426,718.5 мянган төгрөг болж өмнөх оноос 163,577.8 мянган төгрөгөөр буурсан нь 2022 онд Зам засвар арчлалтын ажлын үндсэн түүхий эд материалууд болох Цемент, Хайрга, Битум, Зигзаг, явган хүний замын хавтан, Дизель түлш зэрэг материалуудын үнэ огцом нэмэгдсэнээс шалтгаалан Борлуулсан бүтээгдэхүүний үнэ буюу үйл ажиллагааны зардал өссөнөөс шалтгаалжээ.

### 3.5. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу "Увс АЗЗА" ТӨХК-ийн гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, дээд шатны удирдах байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

**3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Төрийн өмчийн бодлогын зохицуулалтын газрын 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 672 дугаар тогтоолоор "Увс-АЗЗА" ТӨХК-ийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 1,454,545.5 мянган төгрөгөөр, нийт зардлыг 1,423,292.3 мянган төгрөгөөр, ашгийг 31,253.2 мянган төгрөгөөр тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 7,980.0 мянган төгрөгийг төлөвлөсөн байна.

**3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр 1,976,731.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 2,140,309.02 мянган төгрөгийн зардал гаргаж, 163,577.8 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Орлогын эх үүсвэр нь улсын төсвөөс 1,767,178.2 мянган төгрөг, Орон нутгийн чанартай зам засвар арчлалтын ажлаас 209,518.0 мянган төгрөгийн орлого бүрджээ.

Нийт орлогын гүйцэтгэл 1,454,545.5 мянган төгрөг төлөвлөснөөс 1,976,731.2 мянган төгрөг буюу 35.9 хувиар давж биелсэн нь аймгийн ЗДТГ-аас зарласан 2 тендерт шалгарч, гэрээнд тусгагдсан ажлыг гүйцэтгэсэн, төлөвлөгөөнд тусгагдаагүй, Зам тээврийн Хөгжлийн сайдын тушаалаар Автобусны зогсоол шинээр барьсан, Улсын чанартай автозамд үүссэн гэнэтийн эвдрэлийг засварласан Онцгой ажлын санхүүжилтээс голлон нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 1,423,292.3 мянган төгрөг төлөвлөснөөс 2,140,309.0 мянган төгрөгийн бодит зардал гарч, 50.4 хувиар өссөн байна. Энэ нь борлуулсан бүтээгдэхүүний өртөг буюу Улсын чанартай авто замд үүссэн гэнэтийн эвдрэл, бараа материалын үнийн өсөлт, шатах тослох материал, сэлбэгийн үнийн нэмэгдэл, зогсоолын ажил гүйцэтгэхэд 123,000.0 мянган төгрөг, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, Улаангом сумын Ерөнхий боловсролын 4-р сургууль орчмын ажлыг гүйцэтгэх тендерээс 41,000.0 мянган төгрөгийн алдагдал хүлээсэн зэргээс шалтгаалжээ.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу зөөврийн болон суурин компьютер тус бүр нэг ширхэг, 3 үйлдэлтэй принтер 3 ширхэг зэргийг худалдан авахад өөрийн эх үүсвэрээс 7,760,0 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд 163,577.8 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан нь Улсын чанартай авто замд үүссэн гэнэтийн эвдрэл, бараа материалын үнийн өсөлт, шатах тослох материал, сэлбэгийн үнийн нэмэгдэл, Наранбулаг суманд хийсэн зогсоолын ажлын гүйцэтгэлээр 123,000.0 мянган төгрөг, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, Улаангом сумын Ерөнхий боловсролын 4-р сургууль орчмын замын ажлын гүйцэтгэлээр 41,000.0 мянган төгрөгийн алдагдал хүлээсэн зэргээс шалтгаалжээ.

2021 онд 130,015.8 мянган төгрөгийн алдагдалтай ажилласнаас шалтгаалан ТӨБЗГ-т ногдол ашиг төвлөрүүлээгүй байна.

Төлөөлөн удирдах зөвлөл нь хуульд заасны дагуу Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Хувьцаа эзэмшигчдийн төрийн төлөөллийг хэрэгжүүлэгч 7, хараат бус 3, нийт 10 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

2021 онд ТУЗ-ийн үйл ажиллагааны зардалд нийт 25,145.2 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 25,145.2 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна. Үүнд: Цалин, НДШ зардалд 23,240.9 мянга, бусад зардалд 1,904.2 мянган төгрөгийн зардлыг тус тус санхүүжүүлсэн байна.

### *3.5.3 Нэмэлт төсөв*

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тухайн компанид нэмэлт төсвийн данс байхгүй болно.

### *3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн*

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр байхгүй.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу “УВС-АЗЗА” ТӨХК -ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд “УВС-АЗЗА” ТӨХК -ийн орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Дотоод хяналтын талаар оруулж өгөх Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно”, 19.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 4.1.1-д заасан стандартыг мөрдөх үүрэгтэй аж ахуйн нэгж, байгууллага нь дотоод аудитын нэгжтэй байж болно”, 4 дүгээр бүлгийн 4.1.1 дэх хэсэгт “Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт” гэж заасны дагуу “Увс-АЗЗА” ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн Б/04 дүгээр тушаалаар дотоод хяналт, аудит хариуцсан ажилтныг томилсон байна.

Тайлант онд дотоод аудит хариуцсан ажилтан хяналт хийж дараах зөрчил илрүүлсэн ажиллажээ. Үүнд:

- "2022 онд Тэмдэг, самбар гэх зэрэг материалуудыг 108,515.0 мянган төгрөгөөр "Тод тунгалаг тэмдэг" ХХК-аас тендер зарлахгүйгээр шууд гэрээ хийн худалдан авсан бөгөөд цаашид ТБОНӨХБАҮХАТХуулийн дагуу тендер зарлаж байх",
- "2020 онд Улаан уул чиглэлийн замын ажлын зураг төсвийн үнийг захиалагчаас Зураг төслийн компанид шилжүүлсэн байсныг Компанийн

данснаас давхардуулж шилжүүлж авлага тусгасан 10,800.0 мянган төгрөгийг зураг төслийн компаниар яаралтай эргүүлэн төлүүлэх арга хэмжээ авах",

- Ажилтан тус бүрээр цалингийн карт хөтөлдөггүй байсныг "Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 дугаар тушаалаар батлагдсан маягтын дагуу хөтлөх, цаашид хэвшүүлэх",
- "2022 оны 08 дугаар сарын 26-нд хүүхэд асрах чөлөө авсан ажилтны цалинг 2022 оны 10 дугаар сард бүтнээр олгосон байгаа тул эргүүлэн төлүүлэх" гэх зэрэг зөвлөмж өгсөн байна.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Намжил гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан , дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

“УВС-АЗЗА” ТӨХК –ийн 2022 оны санхүүгийн тайлангаа Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

**4.2 Материаллаг байдал**

Материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг төсөвт байгууллагын хувьд суурь үзүүлэлтийг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнгээр сонгох нь зохимжтой гэж үзлээ.

Материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлж, материаллаг байдлын түвшинг 0.5 хувиар тогтоож, сонгосон суурь үзүүлэлтээс тооцож төлөвлөлтийн материаллаг байдлыг 9,381.3 мянган төгрөгөөр тогтоож баримтжууллаа.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 9,381.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн хуулийн “УВС-АЗЗА” ТӨХК-д хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

